

1. ХУВИЙН НУУЦЫН МЭДЭГДЭЛ

- 1.1. Өөрсдийн харилцагчид болон веб сайтад зочлогчдын хувийн нууцыг хамгаалах, хувийн болон санхүүгийн мэдээллийг чандлан хамгаалах нь бидний тэргүүн зорилт билээ. Дараах Хувийн нууцын Мэдэгдэл бид хэрхэн таны мэдээллийг цуглуулж хамгаалдаг тухай тайлбарлана. Данс нээснээр эсвэл Веб сайт ашигласнаар энэ хувийн нууцлалын мэдэгдэлд тайлбарласанчлан хувийн мэдээллийг цуглуулж ашиглах зөвшөөрлийг та бидэнд өгч байгаа хэрэг юм.

2. ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ

- 2.1. Бид данс нээх, бизнесийг үр ашигтай хийх, таны хөрөнгө болон хувийн нууцыг хамгаалахад шаардлагатай мэдээллийг цуглуулдаг. Ингэхийн тулд бид таны хэрэгцээ ба сонголтыг үнэлэхэд туслах мэдээллийг цуглуулдаг.
- 2.2. Бидний таниас шууд цуглуулах мэдээлэлд таны нэр, шуудангийн хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг зэрэг тантай холбоо барих, таныг хэн гэдгийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл багтана. Таныг данс нээх үед бид төрсөн он, сар, өдөр, боловсрол, мэргэжил гэх мэт хувийн мэдээлэл болон таны бидэнтэй изне хийх тухай мэдээллийг багтаана. Мөн бид таны санхүүгийн байдлыг үнэлэхийн тулд таны арилжаа хийж байсан туршлага, таны жилийн баримжаалсан орлого, дундаж цэвэр үнэлгээнд үнэлэлт хийдэг.

3. ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ

Бид танд чанартай үйлчилгээг баталгаатай хүргэхийн тулд хувийн мэдээллийг зохих ёсоор ашиглана. Жишээлбэл, бид таниас цуглуулсан мэдээллийг таны биеийн байцаалт болон холбоо барих мэдээллийг баталгаажуулахын тулд ашиглаж болно. Мөн бид энэ мэдээллийг ашиглан таны арилжааны бүртгэлийг үүсгэж, бүртгэлийн дугаар, хамгаалалтын нууц үг олгож, таны бүртгэлийн үйл ажиллагааг хангаж, дансны мэдээллийн дагуу тантай холбогдоно. Энэ мэдээлэл биднийг танд үзүүлэх үйлчилгээгээ сайжруулах, таны үйлчилгээ ашиглалтыг өөртөө тохируулах, таны сонирхож магадгүй нэмэлт бүтээгдэхүүн, үйлчилгээ юмуу урамшууллын талаар танд мэдээлэхэд тусалдаг.

4. БИДНИЙ ХАМТРАГЧИД БА ТҮНШҮҮД

Тухайн мэдээлэл таны хүссэн бүтээгдэхүүн юмуу үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах эсвэл манай хамтрагчдын санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээнд оролцох боломжийг олгохын тулд мэдээллийг хуваалцаж болно. Манай харилцагчдад үнэ цэнийг өгч болох өндөр чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодог бусад компаниудтай хамтарсан маркетингийн гэрээг багтаасан түншлэл юмуу хамтын ажиллагааг байгуулж

PRIVACY POLICY

болно. Эдгээр бүтээгдэхүүн үйлчилгээ таны хэрэгцээнд нийцсэн, хэрэгтэй, холбогдолтой эсэхийг магадлахын тулд бид зарим мэдээллийг түншүүд, хамтрагчид, салбаруудтайгаа хуваалцаж болно. Ингэснээр тэд өөрсдийн хамгийн их холбогдолтой бас хэрэгцээтэй саналаа илүү сайн ойлгох боломжийг олгодог. Таны хувийн мэдээллийг ашиглахдаа түншүүд юмуу хамтрагчидтай бидний харилцах харилцаагаар тодорхойлсон зорилгоор хязгаарлана.

5. ХАМТРАГЧ БУС ГУРАВДАГЧ ТАЛУУД

- 5.1. Дор тодорхойлсноос бусдаар бид таны хувийн мэдээллийг ямар нэгэн шалтгаанаар гуравдагч этгээдэд худалдах, зөвшөөрөх, түрээслэх, задлахгүй.
- 5.2. Хуулиар шаардсаны дагуу зохицуулах, хууль хэрэгжүүлэх, бусад засгийн газрын эрх бүхий байгууллагад юмуу бидний эрх юмуу эд хөрөнгийг хамгаалахад шаардлагатай үед бид таны хувийн мэдээллийг задлах эрх эдэлнэ.
- 5.3. Танд үзүүлэх үйлчилгээгээ бид сайжруулахад туслахын тулд бүртгэл боловсруулах, захиалга биелүүлэх, харилцагчийн үйлчилгээ, харилцагчийн сэтгэл ханамжийн судалгаа юмуу бусад тусламжийн үйлчилгээ юмуу бидний бизнесийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл цуглуулах зэрэг тодорхой дотоод үйл ажиллагааг явуулахад туслах өөр бизнестэй бид хамтарч болно. Мөн бид харилцагчийн хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, таних, санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаар харилцагчид мэдээлэхийн тулд манай мэдээллийн сангаас харилцагчийн мэдээллийг аль нэг таллд өгч болно. Хуваалцсан мэдээллийн хэрэглээг өөр зорилгоор бус бидний хүссэн ажлын гүйцэтгэлээр хязгаарлана. Хувийн мэдээлэл хуваалцсан бүх гуравдагч этгээдүүд хувийн мэдээллийг бид хэрхэн хамгаалдгийн адилаар хувийн мэдээллийг хамгаалах шаардлагатай байдаг.

6. АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- 6.1. Таны бидэнд өгч байгаа бүх мэдээллийг аюулгүй серверүүдэд хадгална. Бүх төлбөрийн гүйлгээг SSL технологи ашиглан шифрлэнэ. Манай Вебсайтын тодорхой хэсэгт таныг нэвтрүүлэхийн тулд бид танд нууц үг (эсвэл та өөрөө сонгоно) өгөх бөгөөд энэхүү нууц үгийн нууцлалыг та өөрөө хариуцна. Бид таныг нууц үгээ бусадтай хуваалцахгүй байхыг хүсдэг.
- 6.2. Харамсалтай нь интернэтээр дамжуулан мэдээлэл дамжуулах нь бүрэн аюулгүй бус юм. Хэдийгээр бид таны хувийн мэдээллийг хамгаалахын төлөө чадах бүхнээ хийх ч манай Вебсайтад дамжуулсан таны мэдээллийн аюулгүй байдлын баталгаа өгч чадахгүй, харин мэдээлэл дамжуулсан эрсдлийг та өөрөө хариуцна. Бид таны мэдээллийг хүлээн авсаны дараа зөвшөөрөлгүй нэвтрэлтээс урьдчилан сэргийлэхийн тулд бид чанд хатуу журам, хамгаалалтын онцлогийг ашигладаг.

7. ХАРИУЦЛАГЫН ХЯЗГААРЛАЛТ

Хэрвээ та хэзээ нэгэн цагт өөр компанийн санал болгосон бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авах сонголт хийж тухайн компанид хувийн мэдээллээ хуваалцсан бол тухайн мэдээллийг манай Хувийн нууцын мэдэгдлээр хянахгүй. Бидний холбосон сайтуудын хувийн нууцын бодлого юмуу сайтын агуулгыг бид хариуцахгүй бөгөөд тэдгээр сайтуудаас танд өгсөн эсвэл таниас цуглуулсан мэдээллийг ашиглах юмуу хамгаалахад бид хяналт тавьж чадахгүй. Дунд брэндтэй Вебсайт юмуу холбоотой вебсайтад холбогдохоор сонголт хийсэн бол таниас бүртгэлийн юмуу бусад мэдээллийг шаардаж магадгүй. Таны өгч байгаа мэдээлэл гуравп этгээд рүү очиж байгаа учраас тухайн гуравдагч этгээдийн хувийн нууцын бодлоготой танилцана уу.

8. МАРКЕТИНГ

- 8.1. Бид таны мэдээллийг ашиглан таны бонирхож магадгүй бараа үйлчилгээний талаарх мэдээллийг танд өгөхөд ашиглах бөгөөд бид юмуу манай төлөөлөгч энэ талаар тантай шуудангаар юмуу утсаар холбогдож болно.
- 8.2. Хэрвээ та манай хуучин хэрэглэгч бол тантай хийсэн өмнөх борлуулалттай холбоотой бараа үйлчилгээний талаарх мэдээллийн (тухайлбал цахим шуудан, дуут шуудан юмуу SMS) талаар зөвхөн цахимаар холбогдох болно.
- 8.3. Хэрвээ та өөрийн мэдээллийг бидэнд энэ маягаар ашиглуулахыг хүсэхгүй бол өөрийн маркетингийн сонголт хийхдээ холбогдох нүдийг чагтална уу. Та Харилцагчийн Үйлчилгээний төлөөлөгчтэй холбогдон өөрийн сонголтуудаа хүссэн үедээ өөрчилж болно. Хамтарсан бүртгэлийн нэг бүртгэл эзэмшигчийн хийсэн хасалгдах сонголт хамтарсан бүртгэлийн бүх бүртгэл эзэмшигдэд үйлчилнэ. Хасагдах сонголтыг та бидэнд бүртгүүлсэн тусдаа бүртгэл бүртээ хийнэ.

9. “КҮҮКИ” АШИГЛАХ

- 9.1. Бид таны арилжааны үйл ажиллагааг хамгаалах, манай Вебсайтын гүйцэтгэлийг сайжруулахад бидэнд туслахын тулд күүкийнүүдийг ашигладаг. (Күүкийнүүд бол Веб серверээс таны компьютерт илгээдэг жижиг зурвас файл юм.) Бидний хэрэглэдэг күүкийнүүд ямар нэгэн хувийн мэдээлэл юмуу данс эсвэл нууц үгийн мэдээллийг агуулдаггүй. Тэд бол аль хэдийн нэвтэрсэн хүнээс хуудасны хүсэлт ирж байгааг тухайн сайт танихыг зөвшөөрдөг.
- 9.2. Бид Вебсайтад зочилж байгаа зочдын талаарх Вебсайтын хэрэглээний мэдээллийг нэр хүндтэй зар сурталчилгааны компаниудтай хуваалцаж манай Интернэт баннер

PRIVACY POLICY

сурталчилгааг энэ сайт болон бусад сайтууд дээр чиглүүлэхэд ашиглаж болно. Энэ зорилгоор пикселийн шошгыг (бас тодорхой бэлэг юмуу веб дохионы тэмдэгүүд) таны зочилсон хуудсуудыг тэмдэглэхэд ашиглаж болно. Эдгээр пикселийн шошго ашиглахаар дамжуулан зар сурталчилгааны компаниудын цуглуулсан мэдээллийг хувь хүнд хамааруулан танихгүй.

10. ЭНЭХҮҮ ХУВИЙН НУУЦЫН МЭДЭГДЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бид энэхүү Хувийн нууцын Мэдэгдлийг тухай бүрт шинэчилнэ. Энэхүү Хувийн нууцын мэдэгдэлд өөрчлөлт оруулсан тохиолдолд бид шинэчилсэн Хувийн нууцын мэдэгдлийг Вебсайтад даруй байршуулан тухайн өөрчлөлтийн талаар танд мэдээлэх зорилгоор өөрийн Вебсайтаа нийтэлнэ. Шинэчилсэн Хувийн нууцын мэдэгдлийг Вебсайтад цахимаар байршуулах нь танд бодитоор мэдэгдэж байгаа болохыг та зөвшөөрнө. Бидний Хувийн Нууцын Мэдэгдлийн тухай маргааныг энэхүү мэдэгдэл болон манай Харилцагчийн Гэрээний дагуу шийдвэрлэнэ. Бид таныг энэхүү бодлогыг тогтмол шалгаж, хянаж байхыг зөвлөж байна, ингэснээр та биднийг ямар мэдээлэл цуглуулдаг, түүнийг хэрхэн ашигладаг, хэнд тухайн мэдээллийг өгч байгаа тогтмол мэдэх боломжтой юм. Энэхүү мэдэгдлээр хариулаагүй асуулт байвал Харилцагчийн Үйлчилгээний төлөөлөгчтэй холбогдоно уу.